



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 4/358

Хэрлэн сум

Орон нутгийн хамгаалалтын томилгоот
бүрэлдэхүүний сургалт зохион байгуулахад
хөрөнгө зарцуулсугай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.7.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 3.2 дахь заалт, Цэргийн штабын 2025 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хамгаалалтын дадлага, сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд бүсчилсэн хэлбэрээр Баянхутаг, Бор-Өндөр, Дэлгэрхаан сумыг түшиглэн зохион байгуулсугай.


2.Сургалтыг зохион байгуулахад шаардлагатай 8,000,000 (найман сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

3.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

4.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





25/3

۵۲ ۵۵ ۵۸
 بقص بقص (۱۰) بقص (۱۰)

محکمہ انفکھار مر سیٹینجھر دھر
مہینہ سنی و مہینہ سنی و مہینہ سنی و مہینہ سنی و
مہینہ سنی و مہینہ سنی و مہینہ سنی و مہینہ سنی و

[illegible]